



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар A/445

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.1.15, 60 дугаар зүйл 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сум “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил, техник, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт  
хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Л.Бямбасүрэн (Гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах  
байцаагч, хошууч)

Ж.Нацагдорж (Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг дарга)

Д.Түмэнбаяр (Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын  
Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Ж.Улаанбаатар (Хөвсгөл барилга Захиалагчийн хяналтын төвийн  
Хяналтын инженер)

З.Бадрал (Хөвсгөл Эрчим хүч ХХК-ний захирал)

Д.Цанлигрэнчин (Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх  
захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,

Ш.Нямханд (Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн ерөнхий инженер)

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж “Хөвсгөл Дулааны станц” ТӨХК-ийн өвөлжилт, хаваржилтын бэлэн байдалтай танилцаж холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гаргаж цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан аймгийн Онцгой комиссын хурал, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710011700